ОЛОН УЛСЫН АГААРЫН НАВИГАЦИЙН ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН НИСЭХИЙН ХОЛБОО, НАВИГАЦИ, АЖИГЛАЛТЫН АЛБАНААС ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАРЫН ХЭМЖЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛЖ ДАРТСЫН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

2024 оны 10 дугаар сарын 29 Улаанбаатар хот

**Нэг. Зорилго.**

Нисэхийн салбарын хэмжээнд дартсын спортыг хөгжүүлэх, хамт олны эв нэгдлийг бэхжүүлэх, цаашлаад нисэхийн салбаруудаас төрөн гарсан тамирчдыг улс болон олон улсын тэмцээнд иргэний нисэхийн салбарын нэрийг гарган тамирчдыг бүрдүүлэхэд оршино.

**Хоёр. Тэмцээний хамрах хүрээ.**

Уг тэмцээн нь ИНЕГ, ИНҮТ болон түүний харьяа алба салбарууд, авиа компани, зэвсэгт хүчний анги албан хаагчдын дунд зохион байгуулагдана.

**Гурав. Тэмцээн болох хугацаа**

2024 оны 11 дүгээр сарын 12-ний өдөр Нисэхийн спорт цогцолборын хоёр давхрын зааланд 08:00 цагт зохион байгуулна.

Тэмцээний техникийн зөвлөгөөн 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр 11:00 цагт Нисэхийн спорт цогцолборын 2 давхарт болно.

**Дөрөв. Ерөнхий удирдамж.**

1. Эрэгтэй ганцаарчилсан
2. Эмэгтэй ганцаарчилсан
3. Багийн төрөл /2 эрэгтэй, 1 эмэгтэй/

**Тэмцээний журам:**

- Багийн төрөлд тухайн алба салбараас 2-оос ихгүй баг орох боломжтой. Тус төрөл нэг баг нь 2 эрэгтэй, 1 эмэгтэй тамирчдаас бүрдэнэ.
- Nakka.com –оор тоглолт явагдана.
- Бүх тамирчид /Random/ санамсаргүй байдлаар хэсгүүдэд хуваагдаж, хэсэгтээ тойргоор тоглоно.
- Зоонд орсон тамирчид өөрсдөө зоогоо шүүнэ.
- Хэсгийн тоглолт түрүүлж 3 хожил
- Хасагдах шатны тоглолт түрүүлж 3 хожил
- Аваргын төлөөх тоглолт түрүүлж 4 хожил
- Хэсгийн тоглолт 501 онооноос эхэлнэ.
- Хасагдах шат, аваргын төлөөх тоглолтууд 501 онооноос эхэлнэ.
- Тоглолтыг хоёрын үржвэрээр тэглэж дуусгана.
- Өрсөлдөгч нар Nakka систем дээр гарч ирсэн дарааллаар хэн түрүүлж бухын нүдэнд шидэхээ шийдвэрлэх бөгөөд самбарын голд хэн ойр сумаа шидсэн нь тоглолтыг эхлүүлнэ.

- Хэсгийн тоглолтыг эрэмбэлэхдээ тамирчны хожил хожигдлын оноог харьцуулан гаргана.
- Тоглолт 45 сумаар захаа аваагүй тохиолдолд 46 дахь сумаар бухын нүд рүү хэн ойр оносон нь хожил авна.
- 46 сумнаас илүү шидсэн тохиолдолд тоглолтыг зогсоож, дарааллын дагуу бухын нүд рүү хэн ойр оносон нь хожил авна.
- Тамирчид шүүгч болон өрсөлдөгчдөө оноогоо гүйцэт харуулсны дараа сумаа самбараас авна. Хэрэв гүйцэт харуулалгүйгээр сумаа авсан тохиолдолд авсан 3 сумны нийлбэр оноог тооцохгүй.
- Самбараас сум авах үед унасан сумын тоог оноонд тооцох бөгөөд самбарт гар хүрэхээс өмнө унасан сумын оноог оноонд тооцохгүй.
- Хэрэв сум ар араасаа давхралдан зоогдсон тохиолдолд зөвхөн эхний сумны оноогоор тооцно.
- Хэрэв 2 сумны хооронд сум орж ирж тогтоод сумны үзүүр самбартаа хүрсэн бол үзүүр хүрсэн оноог тооцно.
- Тоглолт зарласнаас хойш 10 минутын дотор хүрэлцэн ирээгүй тамирчны тухайн тоглолтыг тэглэж ялалтыг өрсөлдөгч тамирчинд олгоно.
- Маргааныг ерөнхий шүүгч таслан шийдвэрлэнэ.

**Тав.Хураамж**

Нэг тамирчин 10000 төгрөг бооцооны мөнгө хураалгана. Багийн төрөл 30000 төгрөг байна.

Бүртгэлийг /**ХХБ 820015958 Б.Цэнгэл/** дансанд хийснээр баталгаажуулна. Гүйлгээний утга дээр нэр, алба салбар, төрөл, утасны дугаараа бичнэ.

**Зургаа.Тэмцээнийг дүгнэх**

Тэмцээнийг дүгнэхдээ 1, 2, 3, 3 дугаар байр эзлүүлж өргөмжлөл, медаль, мөнгөн шагналаар шагнана.

**Долоо. Анхаарах зүйл**

Зааланд ирэхдээ тоглолтын гуталтай ирэх, улавчтай оруулахгүй!!!

**Найм. Зохион байгуулах комисс.**

Тэмцээнийг Нисэхийн холбоо, навигаци, ажиглалтын алба зохион байгуулна.
Холбоо барих: Р.Цагаанхүү
Утас:99060311

**ХАРАА НЬ ХУРЦ, СУМ НЬ МЭРГЭН БАЙХЫГ ЕРӨӨЕ**